



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/116

Бор-Өндөр сум

Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.5 дахь хэсэг, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын аравдугаар хуралдааны Тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Уурхайчин 4 дүгээр баг галэнтийн тоотод худалдаа эрхэлдэг иргэн Ж.Жавхланд хүнсний дэлгүүрийн тамхи худалдах энгийн зөвшөөрлийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлж, гурван жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тамхи худалдах энгийн зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж 350000 (гурван зуун тавин мянга) төгрөгийг зохих дансанд төвлөрүүлж ажиллахыг татварын Улсын байцаагч (Ц.Баясгалан)-д даалгасугай.

3. Энгийн зөвшөөрлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг 4 дүгээр багийн Засаг дарга (Ч.Саруулмөнх)-д, Бор-Өндөр сум дахь Сум дундын Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа (Т.Энхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ